

ОРОС-МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН ХАРИЛЦААНЫ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД*

В.В.Грайворонский

*Эрхэм хүндэт ШУА-ийн Ерөнхийлөгч ноён Б.Энхтүвшин!
Эрхэм хүндэт ШУА-ийн ОУСХ-ийн захирал ноён Д.Шүрхүү!
Хүндэт хүрээлэнгийн Эрдмийн Зөвлөлийн гишүүг ээ!
Хүндэт хамтран ажиллагсад, найз нар аа!*

Юуны өмнө Монголын ШУА-ийн удирдлага, ОУСХ-ийн Удирдлага, Эрдмийн Зөвлөлийн хамт олонд миний эрдэм шинжилгээний үйл ажиллагааг өндрөөр үнэлж, Монголдоо нэр хүнд бүхий тэргүүлэх нийгмийн ухааны хамт олон болсон Олон Улс Судлалын Хүрээлэнгийн хүндэт доктор цол хүртээж буйд гүн талархал илэрхийлье. 45 жилийн турш ШУА-ийн ОУСХ-ийн эрдэмтэн судлаачдын хэд хэдэн үе нийгмийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, тэр дундаа Монгол орны олон улсын байдал, гадаад бодлогын үзэл баримтлал, үндсэн чиглэлийг шинжлэх ухааны үүднээс судлан боловсруулахад дорвитой хувь нэмэр оруулахын сацуу Монгол улс болон ОХУ-ын найрамдал, хамтын ажиллагаа, түүний дотор танай хүрээлэн болон ОХУ-ын ШУА-ийн Дорнодахины хүрээлэнгийн хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байгаа билээ.

Та бүхний надад санал болгосон "Орос Монголын орчин үеийн харилцааны тулгамдсан асуудлууд" сэдэв нь өргөн хүрээтэй ба нэг удаагийн лекцийн хүрээнд хоёр талын харилцааны бүх чиглэл болон шийдэгдээгүй асуудлуудыг

В.В.Грайворонский – ОХУ-ын ШУА-ийн Дорнодахины хүрээлэнгийн Солонгос, Монгол судлалын хэлтсийн Монголын секторын эрхлэгч, Түүхийн шинжлэх ухааны доктор, Монголын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн хүндэт доктор

Доктор В.В.Грайворонскийд 2013 оны 10 дугаар сарын 2-ны өдөр Улаанбаатар хотноо ШУА-ийн ОУСХ-ийн "Хүндэт доктор" цол хүртээх ёслол дээр уншсан лекц

бүрэн хамрах боломжгүй юм. 2011 онд танай болон манай хүрээлэнгийн хамт олны хамтын бүтээл болсон "Орос ба Монгол Улс стратегийн түншлэлийн замаар"¹ нэртэй ном хэвлэгдэн гарсан нь миний зорилтыг бага боловч гэсэн хөнгөвчилж байна. Энэхүү хамтын бүтээлд сүүлийн 20 гаруй жилд Орос ба Монголын харилцаа хамтын ажиллагаа нь олон улсын тавцанд болон улс төр, худалдаа-эдийн засаг, соёл-хүмүүнлэгийн салбарт гарсан үндсэн өөрчлөлтийг хамтын хүчээр цогц байдлаар задлан шинжлэх оролдого хийсэн билээ. Зохиогчид нь ойрын ирээдүйд хоёр талын харилцаанд гарсан тодорхой ололт болон шийдвэрлэгдээгүй асуудлыг хөндөхийн сацуу боломжийн хирээр хоёр талын харилцааны хандлагыг тодорхойлохыг оролдсон юм.

Энэ бүгдээс үндэслэн миний бие хоёр улсын харилцааны зарим нэг асуудлыг хөндөн ярихыг хүсч байна. Үүнд:

1. Хоёр талын харилцааны өнөөгийн байдлын ерөнхий үнэлэлт
2. Сүүлийн жилүүдийн (2009-2012) тодорхой хэмжээний зогсонги байдлын үндсэн шалтгаан
3. Худалдаа-эдийн засгийн харилцааны үндсэн асуудлууд
4. Шинжлэх ухаан, соёлын салбарын харилцааны асуудлуудын талаар өгүүлье.

Орчин үеийн Орос-Монголын харилцаа: тунхаглал ба бодит байдал

Манай хоёр орны удирдагчид хоёр талын харилцааны өнөөгийн байдлыг үнэлэхдээ уламжлалт, найрсаг харилцаа үргэлжлэн хөгжиж байгаа, шийдвэрлэгдээгүй улс төрийн асуудлууд байхгүй, хоёр талын харилцаа нь олон талтай ба цогц шинжтэй гэж тэмдэглэдэг ба өнөөгийн шатанд стратегийн түншлэлийн шинэ, илүү өндөр түвшинд гарсан гэж үздэг.

ОХУ-ын Ерөнхийлөгч Д.А.Медведевийн Монгол Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр 2009 оны 8 дугаар сард "ОХУ болон Монгол Улсын хооронд стратегийн түншлэлийг хөгжүүлэх Тунхаглал"² гарын үсэг зурсан бөгөөд энэхүү баримт бичигт ойрын ирээдүйд бүх салбарт хамтран ажиллах үндсэн чиглэлийг тодорхойлсон.

Орчин үеийн олон улсын харилцааны асуудлыг судалж буй эрдэмтэд, улс төр судлаачид, эдийн засагчид, соёлын асуудлыг судалж буй та бүхэнд хандан хэлэхэд "ОХУ болон Монгол Улсын хоорондын стратегийн түншлэл" гэсэн ойлголтод ямар тодорхой агуулга багтаж буйг нарийвчлан шинжлэх шаардлагатай байгааг онцлон хэлмээр байна. Магадгүй энэ асуудал тусгай эрдэм шинжилгээний бага хурлын сэдэв ч байж болох юм.

Орос ба Монголын гаалийн албадын судалгаанаас харахад 2012 онд хоёр орны хоорондын гадаад худалдааны эргэлт 1,9 тэрбум долл. хүрсэн ба үүнийг 2011 онтой харьцуулахад 12%³ өссөн дүн гарчээ. Энэ бол гарцаагүй том ололт. 2012 оны 12 дугаар сарын шинэчилсэн бүрэлдэхүүнтэй хоёр орны Засгийн газар хоорондын худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хмтын ажиллагааны хамтарсан Комиссын хурал⁴ болсон.

Өнгөц талаас харахад, миний үзэж буйгаар, сүүлийн жилүүдэд ялангуяа 2009 оноос хойш хоёр талын харилцаанд тодорхой хэмжээний зогсонги байдал, уналт бий болсон ба хөгжил нь ихэвчлэн тунхаглалын шинжтэй байж, зөв тунхаг бичиг ба бодит ажлын хооронд зөрүү гарсныг ажиглаж болно. Үүний тод илрэл нь 2009 онд тохиролцсон Гэрээ, Хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэхэд тодорхой ахиц дэвшил гарахгүй байгаа явдал юм. Тухайлбал, хоёр орны удирдагчдын болон төслийг санаачлагчийн үзэж байснаар манай хоёр улсын хоорондын харилцаанд шинэ эрч хүч, далайц өгч, худалдаа-эдийн засгийн хөгжилд тодорхой ахиц үзүүлэх ёстой байсан хоёр томоохон төслийн тухай асуудлыг энд дурьдах хэрэгтэй. Нэгд, "Дэд бүтцийн хөгжил" гэсэн Орос-Монголын хамтарсан компани байгуулах төсөл ба энэ нь Улаанбаатар төмөр замыг шинэчлэх, Монголд шинээр төмөр зам байгуулах зорилготой байсан. Хоёрт, "Дорнод уран" хамтарсан үйлдвэрийг байгуулах төсөл ба зорилго нь Монголын Дорнод хэсэгт ураныг илрүүлэх, олборлох, баяжуулан ашиглахад оршиж байсан юм. Одоогийн байдлаар монголын тал "Дэд бүтцийн хөгжил" хамтарсан компанийн өөрийн хувиас (50%) бүрэн татгалзаж, энэхүү компанийн 100% акци нь РЖД (Оросын Төмөр Зам) хувь нийлүүлсэн нэгдэлд (ОАО) ногдож байна. "Дорнод уран"

төслийн хэрэгжилт нь олон улсын Арбитрын шүүхэд Монгол Улсын Засгийн Газарт "Хан ресорсиз" компанийн зүгээс хандаж гаргасан нэхэмжлэлтэй холбогдуулан сунжирч байна.

Хоёр талын худалдаанд ч гэсэн шийдэгдээгүй асуудлууд байна. Тухайлбал, Монгол Улсын гадаад худалдаанд Оросын эзлэх хувь багассан, оновчтой бус, өрөөсгөл бүтэц, хоёр орны худалдаан дахь Монгол Улсаас Оростой хийх худалдаанд хасах сальдоны үзүүлэлт өссөн гэх мэт бэрхшээлүүд байна. Олон жилийн турш орос-монголын худалдаанд тэнцвэргүй байдал хадгалагдсаар буй арга хэмжээ нь одоохондоо тодорхой үр дүн авчраагүй байна.

Орос-монголын худалдаа-эдийн засгийн харилцааны харьцангуй зогсонги байдал Монгол улсын Хятад болон "гуравдагч хөрш" орнуудтай (АНУ, Япон, Англи, Өмнөд Солонгос гэх мэт) явуулж буй харилцааны эрчимтэй хөгжлийн хүрээнд илүү тод харагдана. Монголын статистикийн дүн мэдээгээр 2012 онд Монголын гадаад худалдааны эргэлтэд ОХУ 17,3% эзэлсэн байна, тухайлбал импорт-27,4%, экспорт-92,6%-с илүүгүй. Өөрөөр хэлбэл, Монголын экспортын бараг ихэнхи нөөц нэг тал руу чиглэсэн нь Хятад улс бөгөөд, ОХУ-д 2% орчим ноогдож байна.

1990-2012 онуудад Монголын эдийн засагт оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт хэмжээнд Оросын хувь 3% байхад БНХАУ- ойролцоогоор 40% байна.

Иймд сүүлийн 20 гаруй жил (1990-2012 онууд) Монголын Орос Хятадтай явуулж буй худалдаа-эдийн засгийн харилцааны тэнцвэр үндсээрээ өөрчлөгдөж Хятадын талд эерэг гарч байгаа бөгөөд энэ хандлага улам нэмэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор хөрш орнууд болох ОХУ болон БНХАУ-тай тэнцвэртэй бодлого явуулах, аль нэг улсаас хараат байдалд орохгүй байх гэсэн Монгол улсын гадаад бодлогын Үзэл баримтлалын (2011) үндсэн зарчмуудыг сахих тал дээр асуудал гарч байна. Ерөнхийдөө, олон улсын харилцааны өдөр тутмын дадлага ямарваа нэгэн үзэл баримтлалын үндэслэлийг түрүүлж байдаг бөгөөд эдгээр үзэл баримтлалын үнэний шалгуур болдог. Тухайлбал, бидний үзэж буйгаар, Монголын Орос Хятадтай явуулж байгаа худалдаа-эдийн засгийн харилцааны байнгын өсөлттэй томоохон хэмжээний

ийм алдагдал Хятадын талд ашигтай гарч байгаа нь Монголын хувьд ч, Оросын хувьд ч үндэсний эрх ашигт бүрэн нийцэхгүй байна.

Хоёр талын худалдаа-эдийн засгийн харилцааны хөгжлийг удаашруулж буй хүчин зүйлс

"Мөнхийн" буюу уламжлалт Орос-Монгол-Хятад гэсэн гурвалжингийн хүч болон нөлөөллийн үндсэн өөрчлөлтийг тодорхойлж байдаг хүчин зүйлс олон тооны бөгөөд олон янз байх нь тодорхой. Үүний хамгийн чухал бодит хүчин зүйлсийн нэг нь Хятадын гайхалтай өсөлт болон эдийн засгийн хурдацтай өсөлт, Хятадын идэвхитэй, тодорхой чиглэлтэй гадаад бодлого, газар зүйн байршлын хувьд Монголын ашигт малтмалын томоохон орд газрууд монголын түүхийн эд, барааны томоохон зах зээл болон хэрэглэгч болох Хятадын хилийн ойр байгаа гэдгийг онцлох нь зүйтэй болов уу.

Бидний үзэж байгаагаар орос-монголын харилцааны хөгжилд саад болж буй улс төр, эдийн засаг болон бусад хүчин зүйлийн дотор дараахь зүйлүүдийг нэрлэж болно. Үүнд: харилцан зорчих визний дэглэм, монголын уламжлалт экспортыг (мах болон махан бүтээгдэхүүн, арьс шир, ноолууран болон сүлжмэлийн бүтээгдэхүүн гэх мэт) оросын нутаг дэвсгэр, тухайлбал монголын бараа бүтээгдэхүүнийг олон зуун жил хэрэглэж заншсан хил орчмын бүс нутагт нэвтрэхэд хязгаарлалт гэх мэт.

Үүнээс гадна сүүлийн жилүүдийн Монголын тогтворгүй улс төрийн нөхцөл байдал, улс орны удирдлагуудын Өрнө Дорнын өндөр хөгжилтэй-"гуравдагч хөрш" орнуудтай худалдаа-эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан болон цэргийн харилцаагаа түлхүү хөгжүүлж буй, Монголын Орос болон оросын компаниудын хувьд явуулж буй тууштай бус бодлого, урьд өмнө нь өндөр болон дээд хэмжээний уулзалтын хүрээнд байгуулсан гэрээ хэлэлцээрүүдийн хангалтгүй биелэлт, стратегийн ач холбогдолтой томоохон ашигт малтмалын орд газруудыг эзэмших болон гадаадын хөрөнгө оруулалтын салбарын хууль эрх зүйн байнгын өөрчлөлт, Орос болон оросын бизнесийн идэвхитэй бус, хүлээзнэсэн бодлого, хоёр талын идэвхи чармайлт сул, харилцан мэдээлэл

хангалтгүй, хил гаалийн хүнд суртал- энэ бүх хүчин зүйлс худалдаа-эдийн засаг, соёл-хүмүүнлэг, шинжлэх ухаан болон бусад харилцааны хөгжилд сөрөг нөлөө үзүүлж байна.

Иймд бий болсон нөхцөл байдлыг нухацтай хэлэлцэж худалдаа-эдийн засгийн харилцааг идэвхижүүлэх нэмэлт арга хэмжээг авахын тулд өндөр дээд хэмжээний уулзалтуудыг тогтмолжуулах шаардлагатай болсон гэж бид үзэж байна. Үүнтэй холбогдуулан Ерөнхий сайд Н.Алтанхуягийн ОХУ-д хийх албан ёсны айлчлалд бид ихээхэн найдвар тавьж болох байх гэж бодож байна.

Боловсрол болон шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай

1990 он хүртлэх үетэй харьцуулахад орос хэл XX зууны ихэнхи хугацаанд Монгол оронд үндэстэн хоорондын харилцааны үндсэн хэл, гадаад нэгдүгээр хэл болж байсан байр сууриа англи хэлэнд тавьж өгөв. Монголын өнөөгийн албан ёсны бүртгэлийн мэдээгээр болон миний хувийн ажиглалтаар орчин цагийн Монгол хөвгүүд, охидын олонхи нь орос хэлийг ерөөс огт мэддэггүй буюу тун бага мэддэг, дийлэнхидээ өөрсдийн төрсөн эцэг эх, өвөө эмээгийн мэддэг шиг тэр түвшинд яагаад ч хүрэхээргүй болсон нь нэн харамсалтай. Түүнчлэн Монгол Улсын орос хэлээр хэвлэгддэг зарим хэвлэл (жишээлбэл "Өнөөдрийн Монгол", "Монголия сегодня") хаагдах аюулд нэрвэгдээд байна. Сүүлийн жилүүдэд Орос улсын засгийн газраас Монгол улсад орос хэл сурах, Орос судлалыг дэмжиж зарим арга хэмжээ авч байгаа боловч тэр нь огт хангалтгүй байна

Орос, Монголын улс төр, эдийн засаг, зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлтэй холбоотой янз бүрийн бэрхшээл бий боловч манай хоёр орон, юуны урьд хоёр Академийн хоорондын шинжлэх ухааны ба шинжлэх-ухаан техникийн хамтын ажиллагаа уламжлал ёсоор хөгжиж байна. Ийм үр дүнтэй хамтын ажиллагааны үлгэр жишээ гэвэл Оросын Шинжлэх Ухааны Академийн Дорнодахин судлалын хүрээлэн, Монголын Шинжлэх Ухааны Академийн Олон Улс судлалын хүрээлэнгийн хоорондын эртний, уламжлалт хэлхээ холбоог тухайлан хэлж болно. Энэ хамтын ажиллагаа нь төрөл

бүрийн хэлбэрээр, тухайлбал Эрдэм шинжилгээний хамтын бүтээл туурвих ("Орос, Монгол Улс: ХХ зууны харилцааны түүхийг шинээр авч үзэх нь" өгүүллүүдийн эмхтгэл. Москва. 2001 он, "Орос, Монгол Улс: стратегийн түншлэлийн зам дээр" хамтын нэгэн сэдэвт зохиол. Москва. 2011 он. болон бусад) , ОХУ-ын Боловсрол, Шинжлэх Ухааны Яам, Монгол Улсын Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны Грантад хамтран оролцох, хоёр талын эрдэм шинжилгээний бага хурал, гурван талын эрдмийн форумыг хамтран зохион байгуулах, эрдэмтэд, эрдмийн бүтээл харилцан солилцох, нэр бүхий эрдэмтдийн зохиол бүтээлийг хэвлэн нийтлэх, хувийн ажил хэргийн нөхөрсөг хэлхээ холбоо тогтоох гэх мэт хэлбэрээр хэрэгжин биелж байгаа юм.

2011 онд Москвад манай Дорнодахин судлалын хүрээлэн Монголын ШУА-ийн Олон Улс судлалын хүрээлэн, Хятадын Нийгмийн Шинжлэх Ухааны Академийн Ази, Номхон далайн судлалын хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан "Орос, Хятад, Монгол: орчин цагийн хөгжлийн уриа дуудлагыг хамтдаа угтъя" сэдэвт III эрдмийн форумд оролцогчдын илтгэлүүдийн эмхтгэл дөнгөж саяхан хэвлэн нийтлүүлснээ бид авч ирлээ.

Одоо энэ 2013 онд танай хүрээлэн "Ногоон хөгжил бол ХХI зууны Монгол, Орос, Хятадын хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл мөн" гэсэн чухал сэдвээр ээлжит IV эрдмийн форумыг зохион байгуулж байна. Өнөөдөр Оросын Шинжлэх Ухааны Академи өөрчлөлт шинэчлэлтийн хүнд, төвөгтэй цаг үед оршиж байна. Саяхан Оросын ШУА, Оросын Хөдөө аж ахуйн ШУ-ны Академи, Оросын Анагаахын ШУ-ны Академи гэсэн бие даасан гурван Академийг Оросын Шинжлэх Ухааны нэг Академи болгон нэгтгэх тухай, мөн эрдэм шинжилгээний байгууллагуудын аж ахуйн харилцааг зохицуулах үүрэг зорилго бүхий Шинжлэх Ухааны байгууллагуудын Холбооны Агентлаг (ФАНО)-ийг тусгайлан байгуулах тухай Холбооны хуулийг батлан гаргалаа. Энэ үед энэ өөрчлөлт шинэчлэлт Оросын ШУА-ийн Дорнодахины болон бусад хүмүүнлэгийн хүрээлэнгүүдэд, түүнчлэн Оросын Монгол судлалын салбарт хэрхэн яаж тусах эсэх нь одоогоор бүх юм тодорхойгүй байна.

Сүүлийн жилүүдэд Оросын ШУА-ийн Дорнодахины хүрээлэн дэх Монгол судлал нь нэртэй Монгол судлаачид тухайлбал Дорнодахины өргөн хүрээний судлаач, түүхч, улс төрч, эдийн засагч, эрдэмтэн доктор Г.С.Яскина, түүхч, архив судлаач-эрдэмтэн, дэд доктор Г.И.Слерчук нар нас нөхцөж том хохирол амслаа. Мөн нэртэй түүхч, эдийн засагч монголч эрдэмтэн, түүхийн шинжлэх ухааны доктор С.К.Рощин, эдийн засгийн ухааны доктор Ш.Г.Надилов нар гавъяаны амралт, өндөр насныхаа тэтгэвэрт гарцгаалаа. Эдийн засгийн ухааны залуу эрдэмтэн, дэд доктор М.Б.Мещанинов ОХУ-ын ГХЯ-нд шилжив. Тэрбээр одоо Улаанбаатар хотод ОХУ-ын ЭСЯ-нд ажиллаж байгаа.

Өнөөдөр тус хүрээлэнгийн Солонгос, Монгол судлалын хэлтсийн Монголын секторт нэртэй монгол судлаачид: түүхийн шинжлэх ухааны доктор М.И.Гольман, түүхийн шинжлэх ухааны доктор К.В.Орлова, түүхийн шинжлэх ухааны доктор (Ph.D) Е.В.Бойкова болон миний бие В.В.Грайворонский нар үргэлжлүүлэн ажиллаж байна. Бид хэдээс гадна бас хамтран ажиллагчаар өнөөдөр нэртэй эрдэмтэд, тухайлбал Орос Улсын хүмүүнлэгийн Их сургуулийн Монгол-Түвд хэлний тэнхимийн эрхлэгч, хэл шинжлэлийн эрдэмтэн доктор А.Д.Цэндина, М.В.Ломоносовын нэрэмжит МУИС-ийн Ази, Африкийн сургуулийн багш, түүхч-эрдэмтэн Р.Т.Сабиров, Монгол ба Түвдийн түүхийн талаар олон алдартай ном зохиол бичсэн эрдэмтэн С.Л.Кузьмин нар ажиллаж байгаа. Саяхан манай Монголын секторт аспирант залуу, Хятадыг судлаач А.С.Болонов ажиллах боллоо. Тэрбээр Монгол-Хятадын харилцааны түүх ба орчин үеийн хөгжлийн асуудлаар тусгайлан мэргэших юм.

Орос-Монголын харилцааны тулгамдсан асуудлын талаар эргэн ярихад манай орнуудын боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэх түүнийг шинэ шатанд гаргаж дээшлүүлэхэд гол саад болж буй зүйл нь урьдын адил тэдгээрийн хангалтгүй санхүүжилт байгаа юм. Тэр нь манай орнуудын нийгэм-эдийн засгийн хөгжлийн өнөөгийн түвшин болон гадаад эдийн засгийн тэнцвэргүй нөхцөл байдалтай олон талаар холбоотой юм. Орос, Монгол Улсын нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал

сайжирч дээрдэхийн хэрээр, өөрчлөлт шинэтгэлийн явцад Оросын ШУА-ийн байдал төлөв тогтворжихын хэрээр бидний шинжлэх ухааны үр бүтээлтэй хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхэд шинэ шинэ боломжууд бий болно гэдэгт итгэн найдаж байна.

Бас 2011 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачлагаар байгуулсан Монгол судлалын хөгжлийг дэмжих санд тодорхой итгэл найдвар тавьж байна.

Орчуулсан Д.Алтай, Ж.Орхон, Х.Мандухай

ЭШЛЭЛ

¹ "Орос ба Монгол Улс стратегийн түншлэлийн замаар", хар. Ред.А.Б.Рыбаков, Л.Хайсандай, Москва, ОХУ-ын Дорнодахины судлалын хүрээлэн, 2011

² "ОХУ болон Монгол Улсын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх Тунхаг бичиг"

³ www.customs.ru.13.02.2013

⁴ <http://www.mnr.gov.ru/news> 24.12.2012